

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024
оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын
тайлан*

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГАХ**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож
байгаа улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн
хөтөлбөр нь “Алсын хараа-2050”, хуульд заасан шаардлагад нийцсэн байна

АГУУЛГА

Нүүр	1
Товчилсон үгийн тайлбар.....	2
Дүрслэлийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
ДҮГНЭЛТ:	8

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
МАН	Монгол ардын нам

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Нам эвслийн дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ	8



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/25

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах", "Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын ажлын баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор С.Санжаажав)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



009010087

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 11 дүгээр зүйлийн 11.5, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэхэд дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх;*
- *Сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх;*
- *Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д заасан хориглосон зохицуулалттай холбоотой асуудлыг мөрийн хөтөлбөрт тусгасан эсэх;*

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хамруулав.

Аудитын хязгаарлалт

.....

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн дүгнэлт боловсруулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр удирдаж, аудитын менежер У.Батсүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор С.Санжаажав, С.Батцэцэг, Х.Сувдмаа, аудитор Ч.Гантулга, Г.Батмягмар, Б.Алтанзул, Э.Одгэрэл, Н.Отгонцэцэг, З.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэсэн.

Хүндрэл бэрхшээл

Хүндрэл бэрхшээл гараагүй болно.

Ерөнхий мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.10, 37.11-д нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт Төрийн аудитын байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар хуульчилж өгсөн.

Дээрх хуульд нам, эвсэл сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч 07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр заажээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд 8 улс төрийн нам, эвсэл, 35 бие даан нэр дэвшигч мөрийн хөтөлбөр ирүүлж байсан бол 2024 оны ээлжит сонгуульд 14 нам, эвсэл, 3 бие даан нэр дэвшигч оролцохоор мөрийн хөтөлбөр ирүүлсэн.

1. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1¹, 37.5², Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3³-д заасны дагуу сонгуульд өрсөлдөх улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, төрийн аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулахаар хуульчилжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор 14 улс төрийн нам, эвсэл, 3 бие даан нэр дэвшигчээс дүгнэлт гаргуулахаар хуулийн хугацаанд буюу нам, эвсэл 2024 оны 06 дугаар сарын 25, бие даан нэр дэвшигч 07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө мөрийн хөтөлбөрөө Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг ирүүлсэн хугацааны дарааллаар бүртгэж, Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/23 дугаар тушаалаар баталсан аргачлалыг мөрдлөг болгон ажиллаж хавсралт маягтын дагуу мөрийн хөтөлбөрийг гаргаж ирүүлсэн эсэх, мөрийн хөтөлбөр нь хуулийн заалттай нийцэж байгаа эсэхийг шалгах хуудсыг ашиглан дүгнэлт гаргах ажлын баримтыг бүрдүүлсэн.


¹ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна

² Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байна.

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулна.

Сонгуульд оролцох нам, эвслүүдээс мөрийн хөтөлбөртөө нийт 123 бүлэг, 1,652 зорилт, арга хэмжээ, бие даан нэр дэвшигчид нийт 66 зорилт, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгажээ.

Дүрслэл №1



Аудитаар нам, эвслээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг хянахад “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлоготой нийцүүлэн боловсруулсан байв.

Харин ХҮН нам мөрийн хөтөлбөртөө тусгасан санхүүгийн эх үүсвэр шаардсан 7 арга хэмжээг Монгол Улсын Ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/23 дугаар тушаалаар баталсан хавсралтын дагуу гаргаж ирүүлээгүйг аудитын явцад зөрчлийг арилгуулсан.

1.2. Улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид нь мөрийн хөтөлбөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

1.3. Дүгнэлт гаргуулахаар улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг хянахад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д заасан хориглосон нийт 15 арга хэмжээг дараах намууд тусгасан байв. Үүнд:

- Аймгийн МАН иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг 5 арга хэмжээ
- Дархан сумын МАН ажлын байранд зуучлах, ажилд оруулах 3 арга хэмжээ
- Ардчилсан нам хуульд нийцээгүй буюу иргэдэд хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх, мөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох 7 арга хэмжээ тусгасан байлаа.

Дээрх хууль, журамд нийцээгүй мөрийн хөтөлбөр ирүүлсэн намуудад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9⁴-д заасны дагуу нийцээгүй дүгнэлт хүргүүлсэн тул, зөрчлийг арилган дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн мөрийн хөтөлбөрийг дахин хянаж, 14 нам, эвслийн 18 хороо, 3 бие даан нэр дэвшигчид нийцсэн дүгнэлт хүргүүлсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож байгаа 14 улс төрийн нам, эвсэл, 3 бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөрт тусгагдсан нийт 1,718 зорилт, арга хэмжээ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, “Алсын хараа-2050”, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасантай тус тус нийцсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасантай тус тус нийцсэн байна.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

⁴ Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.